



# “ТЭТГЭВРИЙН УУГАН САН” ТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2017 оны 10 сарын 27-ны өдөр

Дугаар 17/09

Улаанбаатар хот

## “Хуримтлал буцаан олгох журам”-ыг шинэчлэн найруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төрийн бус байгууллагын тухай хуулийн 11.1, Тэтгэврийн ууган сан ТББ-ын дүрмийн 4.8.8, Удирдах зөвлөлийн 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын 16/04 тоот тогтоол, Удирдах зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдөр болон 10 дугаар сарын 27 -ны өдрийн хурлуудаас гарсан шийдвэрүүдэд үндэслэн Удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 15/05 тоот Удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан “Хуримтлал буцаан олгох журам”-ын нэрийг “Хуримтлал олгох журам” болгож өөрчлөн, шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
2. Дээрх журмын шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор Удирдах зөвлөлийн 2015 оны 8 сарын 17-ны өдрийн 15/05 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Энэхүү тогтоолыг 2018 оны 01 сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ж.Хишигжаргал/-д үүрэг болгосугай.
4. Журмын шинэчилсэн найруулгыг сангийн гишүүн байгууллага болон гишүүдэд танилцуулах, тэдэнтэй байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, сангийн танилцуулга, цахим хуудас, гэрээний загварт өөрчлөлтийг тусгах, ТУС програмд хуримтлал буцаан олгох тооцоолол хийх аргачлалыг өөрчлөх зэрэг холбогдох бэлтгэл ажлыг 2018 оны 01 сарын 31-ний өдрийн дотор хийж дуусгахыг Гүйцэтгэх захирал /Ж.Хишигжаргал/-д үүрэг болгосугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг Хяналтын зөвлөлийн дарга /С.Төгсбилэг/-г даалгасугай.

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



О.ГАНЖОЛОО



2017 оны 10 сарын 27-ны өдрийн 17/03 тоот тогтоолын Хавсралт

## ХУРИМТЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам (цаашид “Журам” гэх)-ын зорилго нь Тэтгэврийн ууган сан /цаашид “Сан” гэх/-гаас гарсан гишүүний тэтгэврийн нэрийн дансан дахь мөнгөн хөрөнгийг олгох нөхцөл, ажилбартай холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Журам нь Сангийн дүрэм, Сангийн Ерөнхий нөхцөл, Үйл ажиллагааны ерөнхий журам, Гишүүнчлэлийн журам болон Гишүүн байгууллагатай хийсэн гэрээ, ХХОАТ тухай хууль, бусад холбогдох хууль, журамтай нийцсэн байна.
- 1.3 Гишүүн байгууллагын хамтран ажиллах гэрээнд өөрөөр заагаагүй бол ажилтан гишүүнд олгох гишүүн байгууллагын хуримтлалыг энэ журамд заасны дагуу олгоно.

### Хоёр. Журмын нэр томьёо

- 2.1 “тэтгэврийн нэрийн данс” гэж гишүүний болон гишүүн байгууллагын хуримтлуулсан мөнгөн хөрөнгө, түүнд бодогдох өгөөжийг тооцох зорилго бүхий Сангаас бүртгэл хөтлөх тооцоог;
- 2.2 “өөрийн хуримтлал” гэж гишүүдийн цалин болон орлогоосоо өөрийн тэтгэврийн нэрийн дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө;
- 2.3 “ажил олгогчийн хуримтлал” гэж гишүүн байгууллагаас сангийн гишүүн ажилтнаа тэтгэврийн нэрийн дансанд хуримтлуулсан мөнгөн хөрөнгө;
- 2.4 “Ерөнхий нөхцөл” гэж Удирдах зөвлөлөөс баталсан Тэтгэврийн Ууган Сан ТББ-ын Ерөнхий нөхцөлийг;
- 2.5 “өгөөж” гэж тухайн жилд тэтгэврийн нэрийн дансан дахь хуримтлалд ногдох хөрөнгө оруулалтын бодит өгөөжийг хэлнэ.

### Гурав. Хуримтлал олгох үндэслэл, тооцох хугацаа

- 3.1 Ерөнхий нөхцөлийн 4.1-4.4-д заасан нөхцөлүүдэд гишүүнчлэлийн хугацаа дуусгавар болж, хуримтлал олгох үндэслэл бий болно.
- 3.2 Сангийн гишүүнчлэлийн хугацаа дууссан огноог дараах байдлаар тооцно:
  - 3.2.1 хувь гишүүний гэрээний хугацаа дууссан огноогоор;
  - 3.2.2 үндсэн нөхцөлд гишүүний тэтгэврийн хуримтлалаа авах хүсэлтийн огноогоор;
  - 3.2.3 хүндэтгэн үзэх нөхцөлд эмнэлгийн эсвэл шүүх байгууллагын акт баримтад үндэслэн гишүүний эсвэл өв залгамжлагч, итгэмжлэгдсэн хүний хүсэлт гаргасан огноогоор;
  - 3.2.4 хөдөлмөрийн гэрээ цуцлах тухай тушаалд заасан огноогоор;



- 3.2.5 өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээ цуцалж буй гишүүний өргөдөл гаргасан огноогоор;
- 3.2.6 гишүүн байгууллагын хамтран ажиллах гэрээг дуусгавар болгосон огноогоор;
- 3.2.7 сангийн Удирдах зөвлөлийн гишүүдийн тогтоолд заасан огноогоор.

#### **Дөрөв. Хуримтлал олгох зарчим, хэмжээ**

- 4.1. Хөрөнгө оруулалтын бодлогын дагуу сангийн хөрөнгө урт хугацаатай хөрөнгө оруулалтад байршиж жил бүрийн 12 сарын 31-ний 00:00 цагт өгөөж тооцогддог тул гишүүнчлэлийн хугацаа дууссан үндэслэлээс үл хамааран гишүүнчлэлээс гарч буй тухайн жилийн өгөөжийг тооцохгүй.
- 4.2. Ерөнхий нөхцөлийн 4.1-д заасан үндсэн нөхцөлөөс бусад нөхцөлд гишүүнд ногдох хуримтлалыг нэг удаа бүрэн хэмжээгээр олгоно.
- 4.3. Ерөнхий нөхцөлийн 4.1-д заасан үндсэн нөхцөлд гишүүний хуримтлалыг нэг удаа бүрэн хэмжээгээр эсвэл хэсэгчлэн олгож болно. Хуримтлалыг хэсэгчлэн олгохдоо гишүүний “Тэтгэврийн хуримтлалын гэрээ”-г дуусгавар болгож “Хуримтлал хэсэгчлэн авах гэрээ” байгуулан хуримтлал авах хуваарь, хэмжээ зэргийг харилцан тохиролцоно.
- 4.4. Ерөнхий нөхцөлийн 4.2-т заасан хүндэтгэн үзэх нөхцөлд гишүүн эсвэл түүний хууль ёсны өв залгамжлагч, итгэмжлэгдсэн хүнд гишүүний хуримтлалыг бүрэн олгоно.
- 4.5. Ерөнхий нөхцөлийн 4.3, 4.4-д заасан бусад нөхцөл, онцгой нөхцөлд гишүүн байгууллагын хуримтлалыг тухайн заалтад хамаарах хэмжээгээр олгоно.
- 4.6. Гишүүнд олговол зохих хуримтлалын тооцоог хийсний дараа Монгол улсын хууль тогтоомжийн дагуу холбогдох татвар хураамжийг суутгаж, харьяалах төрийн байгууллагад шилжүүлнэ.
- 4.7. Татвар, шимтгэлийн дараах олгох хуримтлалаас Гишүүнчлэлийн журамд заасны дагуу сангийн гишүүний төлөгдөөгүй татвар /хураамжийг суутгасны дараах дүнг гишүүнд олгоно.

#### **Тав. Хуримтлал олгох ажилбар**

- 5.1 Гишүүний гарт олгох хуримтлалыг дараах бичиг баримтыг үндэслэн гишүүний өөрийн /хүндэтгэн үзэх тохиолдолд өв залгамжлагчийн/ нэрийн дансанд шилжүүлнэ:
  - 5.1.1 үндсэн нөхцөлд:
    - 5.1.1.1 тэтгэврийн дэвтрийн хуулбар;
    - 5.1.1.2 гишүүнчлэл цуцлах өргөдөл /Хавсралт №1/.
  - 5.1.2 хүндэтгэн үзэх нөхцөл буюу гишүүн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тохиолдолд:
    - 5.1.2.1 хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоосон эмнэлгийн акт;
    - 5.1.2.2 гишүүнчлэл цуцлах өргөдөл /Хавсралт №1/ эсхүл итгэмжлэгдсэн хүний гараар бичсэн өргөдөл.

- 5.1.1 хүндэтгэн үзэх нөхцөл буюу гишүүн тэтгэврийн насанд хүрэхээс өмнө эсхүл хүрснээс хойш нас барсан тохиолдолд:
  - 5.1.1.1 нас барсны гэрчилгээний хуулбар;
  - 5.1.1.2 өв залгамжлах эрхийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, шүүхийн шийдвэр;
  - 5.1.1.3 өв залгамжлагчийн гараар бичсэн өргөдөл.
- 5.1.2 ажилтан гишүүний хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон нөхцөлд:
  - 5.1.2.1 ажлаас чөлөөлөгдсөн тушаал;
  - 5.1.2.2 гишүүнчлэл цуцлах өргөдөл /Хавсралт №1/
- 5.1.3 гишүүн өөрийн хүсэлтээр сангаас гарахад:
  - 5.1.3.1 Гишүүнчлэл цуцлах өргөдөл /Хавсралт №1/
  - 5.1.3.2 цахим үнэмлэх (хувь гишүүнд хамаатай)
- 5.2 Гишүүний өргөдөлд овог, нэр, регистрийн дугаар, гишүүнчлэл цуцлах шалтгаан, өргөдөл гаргасан огноо, гишүүний хуримтлал хүлээн авах дансны дугаар, холбоо барих утасны дугаар, гарын үсгийг тодорхой бичнэ.
- 5.3 Гишүүний дансанд хуримтлал шилжүүлэхтэй холбоотой гарсан банкны гүйлгээний шимтгэлийг гишүүнд шилжүүлэх дүнгээс суутгана.
- 5.4 Сангийн санхүү хариуцсан ажилтан нь гишүүнээс Гишүүнчлэл цуцлах өргөдөл /Хавсралт №1/ болон бүрдүүлэх материалыг бүрэн хүлээн авч гишүүнчлэлийн хугацаа дууссан огноогоор Тэтгэврийн нэрийн дансыг хааж Гишүүний хуримтлалыг олгох шийдвэр /Хавсралт №2/-ийг бэлтгэж олгох хуримтлалын дүнг тооцож Сангийн Гүйцэтгэх захирлаар батлуулна.
- 5.5 Сан нь гишүүний гарт олгох хуримтлалыг үнэн зөв тооцож, өргөдөл гаргасан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан өргөдлийн ирсэн дарааллаар гишүүний дансанд шилжүүлнэ.
- 5.6 Сан нь гарсан гишүүний тооцоог хийж, улирал бүр гишүүн байгууллагын нягтлан бодогчтой байгууллагад үлдэх хуримтлалын тооцоог нийлж, дараагийн улиралд багтаан буцааж шилжүүлнэ.

\* \* \*



## ТЭТГЭВРИЙН УУГАН САН ТББ-д

### ГИШҮҮНЧЛЭЛ ЦУЦЛАХ ӨРГӨДӨЛ

#### Гишүүний мэдээлэл

Гишүүн байгууллагын нэр: \_\_\_\_\_

Салбар, хэлтэс, албан тушаал: \_\_\_\_\_

Гишүүний дугаар: \_\_\_\_\_ Ургийн овог: \_\_\_\_\_

Эцгийн /эхийн нэр: \_\_\_\_\_ Нэр: \_\_\_\_\_

Регистрийн дугаар: \_\_\_\_\_ Холбоо барих утас: \_\_\_\_\_

Миний бие доорх шалтгааны улмаас сангийн гишүүнчлэлээ цуцалж байгаа тул миний нэрийн дансан дахь хуримтлалыг журмын дагуу тооцон, \_\_\_\_\_ банкны миний өөрийн \_\_\_\_\_ тоот дансанд шилжүүлж өгнө үү.

#### Гишүүнчлэл цуцлах шалтгаан /бүрдүүлэх материал/: Тохирох шалтгааныг сонгоно уу.

- а. Хуульд заасан тэтгэврийн насанд хүрсэн /Тэтгэврийн дэвтрийн хуулбар/
- б. Өөрийн хүсэлтээр хөдөлмөрийн гэрээг цуцалсан /Тушаалын хуулбар/
- в. Ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөрийн гэрээг цуцалсан /Тушаалын хуулбар/
- г. Өөрийн хүсэлтээр сангийн гишүүнчлэлээ цуцалж байгаа
- д. Хүндэтгэн үзэх шалтгаантай /бүрдүүлэх материалыг ТУС-аас лавлах/

#### Санамж:

- Та энэхүү өргөдлийн маягтыг хэвлэж, өөрийн гараар баллаж, засахгүй, гаргацтай бөглөн, гарын үсгээ зураад сканнердан сангийн [info@tus.mn](mailto:info@tus.mn) хаяг руу илгээх эсвэл сангийн байранд өөрийн биеэр авчирч өгнө.
- Хуримтлал олгох журмын дагуу материалыг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 10 хоногт гишүүний хуримтлалыг шилжүүлнэ.
- Хөдөлмөрийн гэрээ цуцалсан тохиолдолд тушаалд заасан огноогоор гаралтын тооцоог хийнэ.

Гишүүний нэр, гарын үсэг: \_\_\_\_\_

Өргөдөл гаргасан: \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр

### ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

Өргөдөл, хавсралт материалыг бүрэн хүлээн авсан: \_\_\_\_\_ он \_\_\_\_\_ сар \_\_\_\_\_ өдөр

Санхүүгийн ажилтны нэр, гарын үсэг: \_\_\_\_\_

**ГИШҮҮНИЙ ХУРИМТЛАЛ ОЛГОХ ШИЙДВЭР**

Дугаар: [ оны сүүлийн 2 орон /шалтгааны код / хэддэх гишүүн ]

..... он....сар.... өдөр

Дараах ..... дугаартай гишүүнийг, түүний Гишүүнчлэл цуцлах өргөдөл үндэслэн гишүүнчлэлээс хасч, Ерөнхий нөхцөлийн ....-д заасны дагуу нэрийн дансан дахь хуримтлалаас гишүүнд ногдох дүнг тооцож олгохоор шийдвэрлэв.

Овог:

Гишүүн байгууллагын нэр:

Нэр:

Албан тушаал:

Регистрийн дугаар:

Гишүүнээр элссэн огноо:

Нэрийн дансны дугаар:

Гарсан огноо:

**НИЙТ ХУРИМТЛАЛЫН ТАЙЛАН**

/төгрөгөөр/

№	Огноо	1. Өөрийн	2. Ажил олгогчоос	3. Нийт 1+2	Тайлбар
1					Хуримтлал
2					Хуримтлал
	Нийт хуримтлал				
					Өгөөж
					Өгөөж
	Нийт өгөөж				
	<b>НИЙТ ХУРИМТЛАЛ</b>	<b>X</b>	<b>XX</b>	<b>XXX</b>	

**ҮҮНЭЭС: ГИШҮҮНД ОЛГОХ ХУРИМТЛАЛЫН НИЙТ ХЭМЖЭЭ**

/төгрөгөөр/

№	Утга	1. Хуримтлалын дүн	2. Олгох хувь	3. Олгох дүн 1*2	4. Суутгасан ХХОАТ 3*10%	5. Татварын дараах дүн
1	Өөрийн оруулсан		0%			
2	Ажил олгогчоос		0%			
3	Өгөөж /өөрийн хуримтлалд ногдох		100%			
4	Өгөөж /байгууллагын хуримтлалд ногдох		20%			
5	<b>НИЙТ ОЛГОХ 1+2+3+4</b>					<b>XXXX</b>

**ГИШҮҮНИЙ ХУРААМЖ, БАНКНЫ ШИМТГЭЛИЙН ТООЦОО**

№	Утга	1. Нэгжийн дүн	2. Хэдэн сар	3. Нийт дүн 1*2	
1	Нийт олгох			XXXX	
2	Гишүүний хураамжийн тооцоо	( )		( )	
3	Банкны гүйлгээний шимтгэл	( )		( )	
4	<b>ГАРТ ОЛГОХ ЦЭВЭР ДҮН 1+2+3</b>			<b>XXXXX</b>	

**ГИШҮҮН БАЙГУУЛЛАГАД БУЦААН ОЛГОХ ХУРИМТЛАЛЫН ТООЦОО**

№	Байгууллагад буцаан олгох тооцоо	1. Хуримтлалын дүн	2. Буцаан олгох хувь	3. Дүн 1*2	
1	Ажил олгогчоос	XX	%	XXXXXX	
	<b>НИЙТ</b>			XXXXXX	

Тайлбар: ХХОАТХ-ийн 13.4-т заасан орлогод 23.1-т заасан хувиар тооцож суутгаж байгаа болно.

Гарт олгох цэвэр дүн: XXXXX төгрөг

Үсгээр: /..... /

Дээрх мөнгөн дүнг ..... овогтой ..... гишүүний  
..... банкны ..... тоот дансанд шилжүүлэхийг зөвшөөрнө үү.

Тооцоолсон: САНХҮҮГИЙН АЖИЛТАН

..... / .....

Зөвшөөрсөн: ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..... / .....